

УЛС ТӨРИЙН ИНСТИТУЦ**ИХ МОНГОЛ ГҮРНИЙ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТ:
АНХНЫ ХОЛБООНЫ УЛСЫН ЗАГВАР****Ц.БАТБОЛД***МУИС. Улс төр судлалын тэнхимийн
дэд профессор, доктор*

Түлхүүр үг: патримониаль бюрократ, бюрократ тогтолцоо, их хаан, бичээч, даргач, их хурилдай, дотоод бичгийн яам, түшмэл ёс, түшмэдийн шалгаруулалт, холбооны улсын загвар, хаангүй төр, тогтвортой байдал, задрал

Товч агуулга: XIII зуунд тухайлбал, 1229-1260 оны үеийн Их Монгол гүрний төрийн байгуулалт холбооны улсын загвартай байсныг нотлох баримтуудаар тодорхойлсон. Илтгэлийн гол зорилго 1229-1260 онд оршиж байсан Их Монгол гүрний төрийн байгуулалтыг шинээр харж, үнэлэлт дүгнэлт өгөхөд чиглэгдсэн. Энэ хүрээнд дараах гурван үндсэн зорилго тавьсан. Нэгд, Их Монгол гүрний төрийн тогтолцооны онцлог. Хоёрт, орчин үеийн холбооны төрийн байгуулалттай улсуудын үндсэн шинжүүдийг Их Монгол гүрний төрийн байгуулалттай холбоотой эмпирик баримтуудад тулгуурлан харьцуулах. Гуравт, 1241-1246, 1248-1251 оны хооронд болсон эрх мэдлийн төлөөх улс төрийн их тэмцлийн үед Их Монгол гүрний патримониаль бюрократ тогтолцоо төрийн тогтвортой байдлыг хэрхэн хадгалж байсныг тодруулах зорилго тавьсан.

* * *

XIII зууны үеийн Их Монгол гүрний төрийн байгуулалтыг түүхч эрдэмтдийн бүтээлүүд, ном-сурах бичгээс үзэхэд 1206 онд анх Чингис хааны байгуулсан Монгол төрийн тогтолцоог ихэвчлэн дурьдсан байдаг. Үүнд хаан, их хурилдай, сэцдийн зөвлөл, их заргач, хишигтэн, баруун, зүүн, төвийн түмэнд хуваасан аравтын тогтолцооны цэрэг, засаг захиргааны зохион байгуулалт болон дам сурвалжуудаас тогтоосон их засаг хуулийн хүрээнд л онцлон авч үздэг. Шинэ байгуулагдсан Монгол улс бүтэн зууны туршид улам хүчирхэгжин бэхжиж, төр улсын удирдлага, түүний бүтэц зохион байгуулалт нь хэрхэн өөрчлөгдөн хөгжсөн талаар өнөөг хүртэл судлан тодорхойлсон судлаачдын бүтээл гарсангүй. Энэ нь нэг талаар тухайн цаг үеийн түүхэн баримт, эх сурвалжуудад их гүрний төрийн байгуулалтын талаар тэр бүр, шууд тодорхойлон тайлбарласан баримтууд ил харагдахгүй байгаатай холбоотой байж болох юм. Гэвч энэ талаар түүхэн баримт, эх сурвалж байхгүй гэж хэлэх боломжгүй бөгөөд тусгайлан эрэн сурвалжилж, нэгтгэн дүгнэсэн судалгаа шинжилгээ огт хийгдээгүй байгаа нь үүний гол шалтгаан болж байна.

Судалгааны хүрээнд Их Монгол гүрний¹ төрийн тогтолцоог Монголын эзэнт гүрэн (1206-1227); Их Монгол гүрэн (1229-1260); Их Монголын задрал ба Юань гүрэн (1261-1368) гэж гурван үе шатад хуваан авч үзэх нь зүйтэй. Уг судалгааны ажил болон илтгэлийн гол зорилго нь 1229-1260 онд оршиж байсан Их Монгол гүрний төрийн байгуулалтыг түүхэн баримтуудад тулгуурлан шинээр харж, үнэлэлт дүгнэлт өгөхөд чиглэгдсэн. Энэ хүрээнд дараах гурван үндсэн судалгааг хийсэн. Нэгдүгээрт, Их Монгол гүрний төрийн тогтолцоо ямар байсан бэ? Хоёрдугаарт, орчин үеийн холбооны төрийн байгуулалттай улсуудын үндсэн шинжүүдийг Их Монгол гүрний төрийн байгуулалттай холбоотой эмпирик баримтуудад тулгуурлан харьцуулан шинжлэх; Гуравдугаарт, 1241-1246 оны хооронд болсон Их хааны суудлын эрх мэдлийн төлөөх улс төрийн их тэмцлийн үед төрийн тогтвортой байдал хэрхэн хадгалагдаж байсныг тодруулах зорилго тавьсан.

Нөгөө талаар харилцаа холбоо, удирдлагын тогтолцоо өнөө цаг үе шиг хөгжөөгүй дундад зууны үед Ази, Европыг дамнасан асар их газар нутаг, олон үндэстэн ард түмнийг хамарсан их гүрэн нэг төвөөс удирдагдан оршин тогтнож байсан нь олон судлаачдын гайхлыг төрүүлсээр ирсэн билээ. Нэн ялангуяа зарим тохиолдолд “Их хаан”-гүйгээр (1227-1229, 1241-1246, 1248-1251 онуудад)-гээр арав гаруй жил оршин тогтнож байсан нь уламжлалт патриархаль нийгмийн хаант засаглал, эсвэл абсолют монархи буюу хэмжээгүй эрхт хаант

¹ Гүрэн: Монголчууд олон улс, үндэстэнээс бүрдсэн улс орныг гүрэн гэж нэрлэж байсан бөгөөд тухайлбал, энэ нь “Могой гурав хуваагдавч гүрвэл хэвээрээ, Монгол гурав хуваагдавч гүрэн хэвээрээ” гэх мэт хэлц үгнүүдэд хадгалагдан үлджээ.

засгийн тогтолцооны үед ч түүхэнд байгаагүй үзэгдэл юм. Дэлхийн аль ч орны түүхэнд хаангүй байсан Афины ардчилал, Ромын бүгд найрамдах улс шиг жишээг эс тооцвол эзэн хаангүй төр улс арван жил бүү хэл, нэг жил ч оршин тогтносон тохиолдол байхгүй билээ.

Тэгэхээр Их Монгол гүрэн их эзэн хаангүйгээр арав гаруй жилийн туршид ямар төрийн зохион байгуулалтын хүчинд оршин тогтнож байсан бэ? гэдэг асуудал гарч ирж байгаа юм. Зарим судлаачид XIII зууны Монголд уламжлалт “хүрээ”² задарсантай холбоотойгоор “Ордны ёс”³ хүчтэй гарч иржээ гэж тайлбарласан байна. Энэ тайлбар нь бага хаант улсуудын хэмжээнд байж болох ч их гүрний хувьд нотолгоо болж чадахгүй гэдэг нь төрийн бюрократ аппаратгүй өмнөх үеийн хаант засаглалуудын тогтолцооноос тодорхой харагдаж байна. Энэ асуудал нь “...Их Монгол улсад төрийн патримониаль бюрократ аппаратын ажиллаж байсан тухай логик үндэслэлийг нэхсэн хэрэг...”⁴ юм.

Их Монгол дахь патримониаль⁵ бюрократ буюу түшмэл ёсны хөгжил

Дорно дахинд бюрократ ёс анхлан төрийн түвшинд хөгжсөн бөгөөд VIII зууны үеэс хятад дахь Тан улс бичиг хэргийн удирдлага, яамдын тогтолцоог хэрэглэж байсныг түүхчид хүлээн зөвшөөрсөн байдаг. Макс Вебер “хятадын мандаринууд нь нийгэмд ноёрхох байр сууриа олж чадсан бөгөөд орчин үеийн оновчтой бюрократын төрөлд шилжиж хувирсан “патримониаль бюрократ”⁶-ын нилээд нийтлэг жишээ мөн”⁷ гэж үзсэн байна.

Их хаан Өгөдэй Алтан улсад хэрэглэгдэж байсан “яамдын тогтолцоо”⁸-г 1237 оноос Их Монголын төрд хэрэглэж эхэлсэн нь “Хар Татарын хэргийн товч”⁹, “Юань улсын судар”¹⁰ зэрэг тухайн үеийн эх сурвалжуудад тэмдэглэгдсэн байдаг. Их хааны засаглалын бүтцийг анхандаа зохих хэмжээгээр боловсорсон дээд ангийнхны үр хүүхдүүд буюу “Хишигтнүүдэд” тулгуурлан бүрдүүлсэн байна. Их гүрний өсөлт хөгжилтөнд энэ нь цаашдаа хангалтгүй болж ирсэн учраас “Улс орныг удирдахад бичгийн мэргэд ихээхэн хэрэгтэй байна гэсэн “Дотоод бичгийн яам”¹¹-ны эрхэлсэн сайд Чу мэргэний (Елюй Чуцай) хүсэлтээр, Өгөдэй хаан “бичгийн мэргэд шалгаруулж төрийн албанд авах тухай” зарлигийг 1235 онд гаргажээ. Төрийн албыг эрдэмтэй авъяаслаг хүмүүсээр нөхөн сэлбэж, тэлэх шаардлагын үүднээс сонгодог зохиол, алба гувчуур, улс орны цаг үеийн асуудал, монгол хэл гэсэн дөрвөн сэдвээр бичгийн шалгалтыг 1237 онд авч, бичгийн эрдэм мэдэх янз бүрийн үндэстэний 4030 хүн шалгаруулалтанд оролцжээ.”¹² “Юань улсын судар”-т Намрын найман сард олон замын бичгийн ардыг шалгахад шалгаж орсон нь уг нутагт хэрэг хэлэлцэх түшмэлээс гадна 4030 хүнийг авсан тухай тэмдэглэжээ.¹³ Ингэж эртний Хятадын төрт улсууд төр захиргааны албадаа эрдэмтэй, авъяаслаг хүмүүсээр нөхөн сэлбэхэд хэрэглэдэг байсан бэлэн энэ журмыг авч ашигласан аж.

Судлаач Д.Наран “Монголын төр ёсны боловсролын түүх” бүтээлдээ түшмэлийг шалгаруулж авах журмын тухай монгол хүнээс хоёр, өнгөт нүдтэнээс гурав, харин хятад хүнээс дөрвөн шалгалт авах тухай дурьдсан байдаг бөгөөд ялангуяа дөрөв дэх шалгалтыг Күнзийн суртлаар авдаг байсан гэжээ. Монгол, хятадаас бусад үндэстэнг “эрээн” буюу өнгөт нүдтэн гэж нэрлэж байсан ажээ. Төрийн албаны шалгалтыг “сонгодог зохиол, алба гувчуур, улс орны цаг үеийн асуудал, монгол хэл гэсэн дөрвөн чиглэлээр авсан ажээ.”¹⁴

² Ц Батболд. Их Монголын төрийн байгуулал дахь холбооны улсын хэв шинж, түүний улс төрийн засаглал нь патримониаль бюрократ тогтолцоотой байсан нь. Түүх V, № 262(33). 2006. х 27. Монголын аймаг, ханлигийн язгууртнууд бэлчээр солин нүүдэллэн буухдаа ойр үйлчлэх албатуудтайгаа хүрээлэн буудаг байсан бөгөөд хүрээний албатууд нь үйлчилгээ, аж ахуй, харуул манаа гэх мэт тодорхой хэмжээний тус бүрийн тусгай үүргүүдтэй байв. Хүрээ гэдэг нэр томъёо нь морин цэргийн гэнэтийн довтолгооноос хамгаалах зорилгоор орд, өргөөгөө тойруулан хүрээлж тавьсан морь давуулдаггүй голоор нь нүхэлсэн гуалинд шургуулан хэрээслэн босгосон “шөрөг” хэмээх модон саадыг хэлдэг байсан бололтой.

³ Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи Түүхийн Хүрээлэн. “Монгол улсын түүх” дэд боть. Ордонд сайд, түшмэл, бичээч, хишигтэн, гэрийн хөвгүүд, эмс охид, сөнчин, буурчин, агтач, хоньчин, үхэрчин гэх зэрэг олон тооны хүмүүс тус тусын чиглэлийн ажил үйлс гүйцэтгэж байжээ.

⁴ Ц Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013. Тод Магнат ХХК. х 143.

⁵ Энэ нэр томъёог XVII зууны дунд үеэс Т.Гоббс улс төрд патримониаль төрийн тухай ойлголт маягаар анх дурьдаж эхэлснээр улс төрийн хэллэгт ашиглагдах болжээ. Патримониаль гэдэг нь латин гаралтай өмч болон өв залгамжлах, гэсэн утгатай үг бөгөөд “өв залгамжилсан хэргэм зэрэг бүхий түшмэлтэй нэг хүний засаглалыг” хэлж буй хэрэг юм. Энэ үгийн үндсийг махчилан буулгавал “нэг язгууртны” гэсэн үг бөгөөд өөрөөр хэлбэл зөвхөн нэг язгууртанд үйлчилдэг түүнээс хараат засаглал буюу нэг хүний улс төрийн бодлогод үйлчилдэг бюрократ ёс аж. Энэ нь хэмжээгүй эрх(абсолют монархи) хаант засгийн шинж төрхийг бүрдүүлдэг сонгодог тогтолцоо байв.

⁶ М Вебер бюрократыг судлахдаа түүний өмнөх нийгмийн түшмэл ёсыг “патримониаль бюрократ” гэж нэрлэн түүнтэй харьцуулан рационал бюрократын концепцийг гаргаж ирсэн ажээ.

⁷ Weber M. Wirtschaft und Gesellschaft. Tubingen, 1976. S.619.

⁸ Ц Батболд. Бюрократонолын үндэс. УБ., 2013. Дорно дахинд бюрократ ёс анхлан төрийн түвшинд хөгжсөн бөгөөд VIII зууны үеэс хятад дахь Тан улс бичиг хэргийн удирдлага, яамдын тогтолцоог хэрэглэж байсан.

⁹ Тухайн үед Хархоринд айлчилсан Өмнөд Сүн улсын элчийн бичиж үлдээсэн “Хар татарын хэргийн товч” хэмээх тэмдэглэлд Их Монголын төрийн яамыг тэд өөрсдийн нэрлэлдээр “Дотоод бичгийн яам” гэж тэмдэглэсэн байдаг.

¹⁰ Д.Мөнх-Очир. Суут одон орон зурхай судлаач Елюй Чуцай. УБ., 2005. х 24. Дам эшлэл. “Юань улсын судар”-т Намрын найман сард олон замын бичгийн ардыг шалгахад шалгаж орсон нь уг нутагт хэрэг хэлэлцэх түшмэлээс гадна 4030 хүнийг авсан тухай тэмдэглэжээ. Дай Юань улсын түүх. Хөх хот. 1987 он. 104-р тал.

¹¹ “Хар татарын хэргийн товч”-д ингэж нэрлэжээ.

¹² Д.Наран, Монголын төр ёсны боловсролын түүх, УБ., 2001, х 99.

¹³ Дай Юань улсын түүх. Хөх хот. 1987 он. 104-р тал

¹⁴ Д.Наран, Монголын төр ёсны боловсролын түүх, УБ., 2001

Дөрөв дэх шалгалтыг Күнз ба моизмын ёс суртахуунд суурилсан төрийн удирдлага, даосизм (бомбын), легизмын хууль, цаазад тулгуурласан төрийн удирдлагын тухай сургаал номлолуудаар авч байсан бололтой. Энд төрийн хэргийг хэрэгжүүлэхэд яс үндэс, угсаа гарвал, нас (тухайн цаг үед патриархи буюу эцгийн эрхт ёс хүчтэй ноёрхож байсанаас энд хүйсийн ялгааг онцолж байсан нь тодорхой тул уг шалгуурт үл хамаарна) үл хамааран зөвхөн мэдлэг чадварыг гол шалгуур болгосон явдал бол орчин үеийн “мерит” зарчим бүхий бюрократад нилээд дөхсөн чадварлаг аппарат бүрдүүлэх үндэс болж байсан бололтой.

Уламжлалт хаант засаглал дахь түшмэдийн онцлог нь ажил хэргийг шийдвэрлэх нарийн хууль дүрэм, журам байдаггүй учраас түшмэл хааны нэрийн өмнөөс аливаа асуудлыг хувийн үзэмжээр шийдвэрлэдэг.¹⁵ Төр, улсын хэргийг шийдвэрлэх нь түшмэл хүнээс ихээхэн мэдлэг чадвар, хүн чанарыг шаардсан ажил байсан бололтой. Тиймээс ч Чингис хаан “төр ёс мэддэг нэг хүн түмэн хүнээс ч дээр буюу” хэмээн хэлсэн буй за. Дундад зууны улс орнуудад түшмэл хүний үндсэн шинж хэмээх шалгуур үзүүлэлтийг гаргаж ирсэн байдаг. Үүнд:

1. Бичиг эрдэмд суралцсан байх.
2. Сурвалжит язгуур угсаатай байх.
3. Өршөөнгүй сэтгэлт. Нигүүлсэнгүй сэтгэлийг барьж ард түмнээ асрагч байх.
4. Хаанд үнэнч шударгаар зүтгэх.
5. Төр ёс, хууль журмыг баримтлах.
6. Төвшин ухаан сэтгэлийг эрхэм болгосон ноён нуруутай байх гэх зэрэг төгс

хүний тухай сургааль номлол ихээхэн яригдаж иржээ. Гэвч амьдралд эдгээр шалгуурт тэнцэх төгс хүн ховор байдгаас гадна их гүрний төрийн албыг гүйцэтгэх олон тооны чадварлаг албан хаагчид зайлшгүй хэрэгтэй болсоноос үүдэж бюрократ ёс хөгжсөн бололтой. Тиймээс түшмэл ёсноос харьцангуй өөр албан хаагчийн тогтолцооны шинж чанар “патримониаль бюрократ”¹⁶-д ажиглагддаг. Патримониаль бюрократ удирдлагын үндсэн зарчмууд нь:

1. Эрх мэдлийн шаталсан зохион байгуулалт. (эрхэлсэн, туслах, ялгах түшмэл)
2. Эрх мэдлийн хүрээнд бүрэн эрхтэй байх. (ажил үүргийн хуваарь)
3. Албан хаагчдыг /түшмэл/ мэргэшлийн ур чадварт үндэслэн томилох. (шалгалтын тогтолцоо)
4. Албан тушаалын зэрэглэлээр цалинжих.
5. Албан хаагчид ажилдаа мэргэшсэн байх.
6. Албан хаагч өөрийн ажиллаж буй байгууллагыг эзэмшдэггүй байх.
7. Албан хаагчид ёс зүйн болон захирах, захирагдах ёсыг сахих.
8. Байгууллагын бүх үйл явц бичгээр илэрхийлэгдэн үлддэг байхээрэг юм. М.Вебер

“Патримониаль бюрократ бол рационал бюрократ шинжийг бүрэн хангаж чаддаггүй ч түүний үндсэн зарчмууд ямар нэг хэмжээгээр хадгалагдаж байдаг” гэж үнэлсэн байдаг.

Өгөдэй хааны үед “Хар хүрэм”¹⁷-д Их Монголын төрийн байгуулал тодорхой хэмжээнд төрөлжих шинжтэй болсон бөгөөд “Алтан улсын жишгээр Чжуншүшэн буюу Дотоод бичгийн яам гэгч төв гүйцэтгэгч байгууллагыг зохион байгуулж, хот суурин газар монгол даргач нарыг суулгажээ”¹⁸. Мөнх хааны үед очсон Францын вангийн элч шашин номлогч Гельеом де Рубрук “...Эдгээр хорооны гадна ордны түшмэдийн олон том ордон байрлана.”¹⁹ гэж бичсэн байдаг нь төрийн түшмэлүүдийн ажлын байр буюу эдүгээгийн яамдыг хэлсэн бололтой. Тухайн үед Европт яамны тухай ойлголт огт байгаагүй учраас түшмэдийн ордууд гэж нэрлэсэн бололтой.

“Өгөдэй хааны үед Монгол угсааны Кидан гаралт Елюй Чуцай буюу Чу мэргэн Дотоод Бичгийн Яамны (ДБЯ) эрхэлсэн чинсан (сайд), ДБЯ-ны зүүн этгээдийг хариуцсан тэргүүн чинсан Зүрчид гаралт Наньхэжуншан, ДБЯ-ны баруун этгээдийг хариуцсан тэргүүн чинсан буюу сайд нь Хэрээд угсааны Чингай байжээ. Өмнөд Сүн улсын элч Сюй Тин, Пэн Дая нарын “Хар татарын хэргийн товч” хэмээх тэмдэглэлд “... дөрвөн сайд байхаас Илжигдэй, Ила Чуцай (Елюй Чуцай), Наньхэжуншань нар хятад газрын хэргийг хамаарна. Төрийн асуудлаа Ила Чуцай, Чингай хариуцдаг. Тэд бие биенээ “бичээч” гэж дуудна, овог хэрэглэнэ гэж үгүй ...бичиг хэрэг хариуцдаг хүнээ “бичээч”, ард иргэдийг хариуцдаг хүнээ “даргачи” хэмээн

¹⁵ М.Вебер. Избранные произведения. М., 1990.

¹⁶ М.Вебер патримониализмыг шинэ ач холбогдлын ойлголтоор баяжуулж өгсөн төдийгүй, уламжлалт засаглалын төрлүүдийн нэг хэлбэр бөгөөд “анхдагч” патриархализмаас үүсэлтэй гэж үзсэн. Өрнөдийн судлаачид М.Веберийн зохиол бүтээлүүдийг 1960-аад оны үеэс идэвхтэй сэргээн судлах болсон. Үүний үр дүнд зарим судлаачид М.Веберийн бюрократын социологийн асуудлууд болох одоог хүртэл хэнд ч мэдэгдээгүй зарим нэгэн зүйлд ихээхэн ач холбогдол өгөх болжээ. Тухайлбал, М.Эльбругийн тодорхойлсноор “М.Веберийн ерөнхий концепцийн нэг” бол “патримониаль бюрократ” хэмээх ойлголтын тухай асуудал юм гэжээ. Учир нь М.Вебер бюрократыг судлахдаа түүний өмнөх нийгмийн түшмэл ёсыг “патримониаль бюрократ” гэж нэрлэн түүнтэй харьцуулан рационал бюрократын концепцийг гаргаж ирсэн ажээ.

¹⁷ Уйгарын Пэйло хаан Хүрэмт уул, Хун голын хөндийд “Орду Балык” буюу орд балгасаа байгуулж байсан нь Хар хорины эртний нэр Хар хүрэм хэмээх галт уулын хүрмэн чулууны хойд захын уулын нэрээр нэршсэн байх магадлалтай юм.

¹⁸ Д.Наран, Монголын төр ёсны боловсролын түүх, УБ., 2001, х 99.

¹⁹ Г.Рубрук, Дорно этгээдэд зорчсон минь, УБ., 1988, х 193.

дууддаг” гэжээ.²⁰

Бюрократ удирдлагын үйл ажиллагаа албан бичгээр хэрэгждэг бөгөөд монголчууд төрийн ёсны бичгийн хөгжлийн эртний соёлтой, бюрократ элемент тодорхой хөгжиж байсан орны нэг мөн гэдгийг Их Монгол гүрний албан бичгийн соёл илтгэдэг. Их Монгол улсын уламжлалт албан бичиг нь бүтцийн хувьд толгой, үндсэн хэсэг, батламж гэсэн гурван хэсгээс бүрддэг байсан нь өнөөгийн албан бичгийн эх үүсвэр бөгөөд бараг тэр чигээр нь өнөө үед ашиглагджээ. Их Монгол улсын албан бичгийн дээд талын сул зайны дунд хэсэгт “Өргөх бичиг”, “Айлтгах бичиг”, “Өргөн барих бичиг” гэсэн байвал доороос буюу доод тушаалтнаас дээд газар болон дээд тушаалтанд явуулсан бичиг болох нь мэдэгддэг. Харин “Тушаах бичиг”, “Мэдтүгэй хэмээх бичиг”, “Зарлиг” гэх мэтчилэн бичсэн байвал дээрээс доошоо явуулсан тушаал шийдвэр, зарлигийн бичиг байдаг. Мөн Их Монгол улсын албан бичгийн ёсонд албан бичгийн төгсгөлд “Үүний тул мэдтүгэй”, “Үүний тул өргөв” гэх мэт бичдэг нь уул бичгийг явуулсан зорилгыг давтан сануулж, алгуурлаж болохгүй, гүйцэтгэх хэрэгтэй, одоохон хариу ирүүл гэсэн санааг дипломат ёс намбатайгаар сануулсан байдаг. Харин бичгийн эхэнд хаанахын ямар албан тушаалтай хэнээс хаана, ямар удирдлагын албаны хэнд, юуны учир явуулсан бичиг болохыг уул албан бичгийн эхэнд шууд бичдэг байсан нь албан бичгийн нэр сүрийг өргөдөг эрхэм ёс байжээ. Мөн ялгах түшмэлүүд албан бичигт тамга дарсан он сар өдрийг нарийн хөтөлдөг байсан байна.²¹

Ил хаан Өлзийтийн Францын ванд илгээсэн захидлын эхэнд Өлзийт султан үг мину гэсэн толгой байгаа нь тухайн албан бичгийг Өлзийт хааны захидал гэдгийг тодотгож өгөөд зогсохгүй гарчгийн дэргэд төрийн тамгаа дарж баталгаажуулсан байна. Захидлын төгсгөлд “Мөнх тэнгэрийн ташуурын үг мину” хэмээсэн нь захидлын агуулгыг давтан сануулж, хүчжүүлсэн аж. Энэ нь дээрх албан бичгийн загварын ёс журам, хэвшлийг агуулж байгаа нь Их Монгол улсын төрт ёсны болон түшмэл ёсны хөгжил өндөр түвшинд байсныг баталж байгаа билээ.

VIII зууны Тан династын үеэс уламжилсан хятадын бюрократ ёс Алтан улсаар дамжин монголд орж ирсэн нь тодорхой юм. Бюрократыг судалдаг хойд хөршийн дийлэнх судлаачид Оросын бюрократ нь өрнөдийнхөөс өвөрмөц, өөрийн гэсэн өнгө аяс суурьтай, энэ нь Монголын дарангуйллаар дамжин хятадаас орж ирсэн бололтой гэж үзсэн байдаг. Тухайлбал, оросын судлаач А.В.Оболонский “Орост XIII зуунаас Византи, Татарын загварууд хослон голчилж байсан. Гэвч сүүлчийн хятадын бүдүүвчилсэн загвар нь ихэвчлэн татвар хураах хэлбэрээр хэрэгжиж байсан юм. Ийм гайхалтай хэлбэрээр Алтан Ордны үеийг дамжин хятадын бюрократ загвар Орос улсад орж ирсэн”²² гэжээ.

Энэ нь Ази Европыг дамнасан их гүрнийг оршин тогтноулж, удирдахын тулд “Өгөдэй хаанд төр захиргааны гүйцэтгэх аппарат шаардлагатай байсан нь тодорхой бөгөөд энэ зорилтын хүрээнд бичгийн мэргэдэд тулгуурласан иерархи буюу шатлан захирах патримониаль бюрократыг хөгжүүлэхээс өөр аргагүй байдалд хүрсэний шинж ажгуу.”²³ Их Монгол гүрний төрийн аппарат, зөвхөн дотоод бичгийн ямаар хязгаарлагдаагүй бөгөөд тухайлбал, “Өгөдэй хааны үед гааль, татварын систем тогтож, 100 малаас 1 мал, 10 таар амуунаас 1 таар амуу санд авч байх журмыг тогтоож”²⁴ гүйцэтгэх татварын алба, нийслэл Хархүрэмд ирж худалдаа хийж буй гадаад дотоодын худалдаачдад худалдааны зарим онцгой эрхийн пайз²⁵ олгодог газар, өртөөний албыг зохицуулж байсан “Замч”²⁶ буюу өртөөний алба зэрэг олон төрийн тусгай албадууд ажиллаж байсан дам баримтууд байдаг.

Патримониаль бюрократ загварын гол зарчим нь тухайн эзэнт улсын эзэн хааныг болон төрийг дээдлэх зарчим гол бөгөөд түшмэд нь эзэн хаанаар толгойлуулсан их гэр бүл буюу төрийн өмчийг эрхлэгчид төдий юм. Патримониаль бюрократын зорилго нь нийгмийн сонирхолд үйлчлэх бус харин тэнгэр заяат эзэн хааны буюу төрийн засаглалын тогтвортой нөхцлийг хангаж байхын тулд хүмүүсийн сайн, муу үйлдлийн сөрөг үр дагаварын нөлөөллийг зөөлрүүлэх үүрэгтэй байжээ.

²⁰ Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013. Тод Магнат ХХК. х 151-252.

²¹ Ч.Арьяасүрэн. Х.Нямбуу. “Монгол зан заншлын Их тайлбар толь” УБ., 1992. Сүүлэнхүү ХХК. х128.

²² А.В.Оболонский. Государственная служба, М., 2000. Дело.

²³ Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013.

²⁴ Монголын дундад зууны үеийн гаалийн харилцаа МЭӨ 13-20 зуун. XII-XIII зууны үед Монголын хаад эзэнт гүрний хэмжээнд явагдаж байсан худалдааг хааны сан хөмрөгийг арвижуулах бодлогоор явуулж байлаа. Энэ зорилгын үүднээс худалдаанд гааль татвар ногдуулах журам тогтоожээ. Түүхэн ном зохиолоос үзэхэд Монголын хаад ноёд эзлэгдсэн орны ард түмнээс алба, гувчуур, тагар/таар/, тамга/улаа, шүүс/ зэрэг олон нэр төрлийн татвар хурааж байжээ. Оросын гаалийн албаны түүхийн тухай ном бичсэн Л.Н.Марков Орос дахь Монголын эзэмшлийн үед орос хэлэнд “тамга” гэдэг монгол үг орсон. Тэр үед хааны тамга бүхий зарлигийг эзэмшсэн ноёд феодалууд ард олноос татвар хураах эрхтэй байсан байна. Энэ бүхнээс үзэхэд Монгол нутагт гаалийн харилцаа үүссэн нь их л дээр үед хамрагдах бөгөөд XIII зууны үед худалдааны бараа таваараас гааль татвар хурааж, улсын санд оруулах систем бүрэлдэж байжээ.

²⁵ Б.Уламбаяр. Гадаад болон дотоод худалдааны түүхэн тойм. Хожим “Их хаан Аргуны үед Худалдааны холбоо гэдэг байгууллага үүсч Азийн олон улсын худалдааны онц эрхийг барьж байв.”

²⁶ Монголын нууц товчоо. ... Өгөдэй хаан өгүүлрүүн: “Хаан эцгийнхээ их сууринд сууж, хаан эцгээс хойш үйлдсэн минь: Жахууд иргэн /Алтан улс/-д аялж, Жахууд иргэн /Алтан улс/-г мохоов, би. Нөгөө үйл минь бидний хооронд элч үтэрлэн довтолгохуй, бас хэрэг заргаа зөөлгөх зам тавиулав. Бас нөгөө үйл нь усгүй газар худаг эрүүлж, гаргуулж, улс иргэдийг ус өвсөнд хүргүүлэв. Бас зүг зүг хот балгадын иргэдэд алгинчин /толгойлогч/, тамгачийг тавьж, улс иргэнийг хөл хөсөр, гар газар тавиулж агуулав, би. Хаан эцгээс хойш энэ дөрвөн үйлсийг нэмэв ээ.

Төрийн засаглалыг хаанаас хараат түшмэдээр гүйцэтгүүлэн улс орныг хяналтандаа авч, тогтвортой засаглалыг бий болгох зорилго агуулж байсан европын XVII-XVIII зууны үеийн бюрократизмээс өмнөх төрийн хэв шинжийг ийнхүү нэрлэжээ. "Патримониаль" гэсэн ойлголт нь Ромын эзэнт гүрнээс эх үүсэлтэй. "Августын засаглалын үеэс patrimonium гэдэг нэр томъёо эзэн хааны (император) хувийн хөрөнгийг илэрхийлж байсан бөгөөд эзэн хаан сенатат тайлагнахгүйгээр өөрөө захиран зарцуулдаг байв"²⁷

Төрийн байгуулалттын харьцуулалт

Орчин үеийн төрийн байгуулалтын холбооны загварын үндсэн шинжүүд:

1. Холбооны нэгдсэн ерөнхий засаглалтай байна. Холбооны төрийн байгууламж нь үндэстэний ба газар нутгийн холбооны улс гэж хоёр хэлбэртэй. Учир нь үндэстнүүд болон газар нутгаар холбооны муж улсууд нь хуваагддаг. Тухайлбал, үндэстэний холбооны улсад ОХУ, Энэтхэг зэрэг олон үндэстэнээс бүрдсэн улсууд хамаарагддаг. АНУ, ХБНГУ, Швейцарь зэрэг олон улс орнууд газар нутгийн холбооны төрийн байгууламжтай.
2. Засаглал хуваах тогтолцоо үйлчилдэг. Холбооны улсууд хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх засаглалыг хуваахгүйгээр орших боломжгүй. Засаглал хуваасан тохиолдолд ерөнхийлөгчийн болон парламентын бүгд найрамдах улсын хэлбэрийн аль нэгийг сонгодог.
3. Засаглалын хоёр тогтолцоо үйлчлэх. Холбооны ерөнхий засаглал ба муж улсуудын засаглал оршдог. Төрийн үндсэн үүргийг холбооны засаглал шийдвэрлэдэг бол муж улсуудын засаглал улс төр, нийгэм, эдийн засгийн дотоод асуудлаа өөрөө бие даан шийдвэрлэдэг онцлогтой.
4. Хуулийн хоёр систем үйлчлэнэ. Холбооны ерөнхий хууль ба муж улсуудын хууль үйлчлэх бөгөөд муж улсуудын хууль нь холбооны ерөнхий хуулийг зөрчөөгүй бол хоорондоо өөр өөр байж болдог. Муж улсын хууль нь түүний онцлог (газар нутаг, хүн ам, соёл, нийгэм эдийн засгийн хөгжил зэрэг)-ийг илүү тусгасан байдаг.
5. Татварын гурван систем үйлчлэнэ. Холбооны, муж улсын, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын гэсэн татварын тогтолцоотой. Энэ нь гурав дахин их татвартай гэсэн үг биш бөгөөд төр нь иргэд, аж ахуйн нэгжүүдээс авах татвараа гурав хуваадаг.
6. Хууль тогтоох 2 танхимтай парламент. Байнгын ажиллагаатай парламентын танхим ба орон нутгийн иргэдийн төлөөллийн танхимтай. Холбооны улсууд нь ерөнхийлөгчийн болон парламентын засаглалтай байдаг. АНУ, Бразил, ОХУ зэрэг нь ерөнхийлөгчийн засаглалтай бол, Герман, Энэтхэг, Швейцарь зэрэг холбооны улсууд парламентийн засаглалтай.
7. Холбооны болон муж улсууд, орон нутгийн төсөв тусдаа байна. Орон нутгийн бие даасан байдлыг хангадаг учраас холбооны болон муж улсууд болон өөрөө удирдах ёсны байгууллагын төсөв тус тусдаа батлагддаг.
8. Холбооны ерөнхийлөгч. Бүх ард түмнээс сонгогдоно. Ерөнхийлөгч гүйцэтгэх засаглалыг тэргүүлнэ. Олон үндэстний холбооны улс төрийн нэгдмэл байдлыг хадгалан, задралаас сэргийлэх үүднээс ихэнх тохиолдолд хүчтэй ерөнхийлөгчийн засаглалтай байдаг.²⁸
9. Шүүх засаглал. Дээд шүүхийн шүүгчид болон бүх шатны шүүхийн шүүгчид ард түмэн болон улс төрөөс үл хамааран зөвхөн мерит болон шударга ёсны зарчимд тулгуурлан бүх насаараа томилогддог.
10. Нутгийн өөрөө удирдах ёсны бие даасан байдал. Нутгийн удирдлага нь хүмүүсийн нийгмийн амьдралын анхан шатны зохион байгуулалттай элемент бөгөөд хүй нэгдлийн үед коммун буюу хамтын, нүүдлийн болон газар тариалангийн нийгмийн үед хамжлагын, албат ардын хэлбэрээр буюу нийгмийн жам ёсны патриархи онолоор, капитализм, социализмын буюу нийлмэл нийгмийн үед дуализмын болон төрийн онолоор, орчин үед үйлчилгээний онолоор хэрэгжиж байна.
11. Төрийн хэргийг албан ёсны нэг хэлээр явуулдаг. Үндэстэний холбооны улсад олон хэлтэй үндэстэнүүд зэрэгцэн оршдог ч тэд үндэстний олонхийн болон удирдаж үндэстэний хэлийг төрийн хэл болгодог.
12. Олон шашин зэрэгцэн орших боломжтой байх. Төр улсын нэгдмэл байдлыг хангах, шашин хоорондын зөрчлийг гүнзгийрүүлэхгүй байлгах зорилгоор шашин шүтэх эрх чөлөөг олгоод зогсохгүй, аль нэгийг нь онцлохгүй байх.
13. Нэгдмэл холбооны зэвсэгт хүчинтэй байх. Орчин үеийн холбооны төрийн байгууламжтай улс орнууд бүгд нэг нэгдсэн зэвсэгт хүчинтэй байж, аюулгүй байдлаа хамгаалдаг.

²⁷ Kamenka E. Bureaucracy. Oxford, 1989. P.63.

²⁸ Газар нутгийн холбооны улс АНУ, Бразил, үндэстэний холбооны улс ОХУ-ууд хүчтэй ерөнхийлөгчийн засаглалтай. Харин ХБНГУ, Энэтхэг, Швейцарь зэрэг парламентийн засаглалтай холбооны улсууд хүчтэй ерөнхий сайд буюу гүйцэтгэх засаглалтай байдаг.

Холбооны төрийн байгуулалтын ерөнхий шалгуураар Их Монгол гүрнийг харьцуулсан нь

	Орчин үеийн холбооны төрийн байгуулалтын үндсэн шинжүүд	Их Монгол гүрний төрийн байгуулалтын үндсэн шинжүүд	Баримт, тайлбар
1	Үндэстэний ба газар нутгийн холбооны улс. Үндэстнүүд ба газар нутгаар холбооны муж улсууд нь хуваагддаг.	Үндэстэний холбооны улсын шинжтэй	Эзлэн авсан болон дагаар орсон улсуудыг таслан хуваагаагүй. МУ-ын түүх УБ., 1968.
2	Засаглал хуваах тогтолцоо үйлчилдэг.	Их Хурилдай, Төрийн “Их Заргач” бүхий шүүх, Их хааны засаг	Их Хурилдай парламентийн үүргийг гүйцэтгэж чадахгүй ч Их гүрний шинжтэй дайн, эрхийн томоохон асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргаж байсан.
3	Засаглалын хоёр тогтолцоо үйлчлэх. Холбооны ерөнхий засаглал ба муж улсуудын засаглал;	Их хааны засаглал ба бага хаадын засаглал	Алтан Ордны хаан П.Карпини, Г.Рубрук нарын асуудлыг “би шийдвэрлэх эрхгүй” хэмээн Их хаан руу явуулж байв. П.Карпини. Монголчуудын түүх. 1988. Г.Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. 1988.
4	Хуулийн хоёр систем үйлчилнэ. Холбооны ерөнхий хууль ба муж улсуудын хууль;	Холбооны ерөнхий хуулийг “Их Засаг” хууль, бага хаант улсуудад дотооддоо тухайн орны хуульд нийцүүлэн шийдвэрлэж байв.	“Их засаг” хууль дахь “Алив шашин суртлыг онцлойлон үзэхгүй” хэмээх заалт бага хаант улсуудад ч үйлчилж байв. Рашид-Ад-Дины “Судрын чуулган” Бага хаант улсууд “Их засаг” хуулийн хүрээнд Перс, Орос, Хятадад өөрсдийнх нь хуульд түшиглэн засаглалаа хэрэгжүүлж байв. МУ-ын түүх УБ., 1968.
5	Татварын гурван систем үйлчлэнэ. Холбооны, муж улсын, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын;	Засаглалын тогтолцоо үндсэндээ татвар хураах системд суурилсан. Бага хаант улсууд татварын нэг хэсгийг Их хааны санд жил бүр илгээдэг.	Тухайлбал, Алтан Ордны улс татвар хураахын тулд хүн амын тооллого явуулж байсан бөгөөд Их хааны санд “ширток” хэмээх мөнгөн гулуузаар татвар төлж байсан. Монголын эзэнт гүрэн ОУ-ын баримтат кино
6	Хууль тогтоох хоёр танхимтай парламент. Төлөөлөгчдийн танхим ба байнгын ажиллагаатай парламентын танхим;	“Их Хурилдай” – сонгодог утгаараа язгууртны дээд танхимийн үүргийг гүйцэтгэж байв. Гэхдээ байнгын ажиллагаат парламентын тогтолцоо байхгүй.	Засаглал нь ардчилсан бус учраас энэ нь боломжгүй.
7	Холбооны болон муж улсуудын төсөв тусдаа байх; Орон нутгийн бие даасан байдлыг хангадаг учраас холбооны, муж улсуудын болон НӨУЁБ-ын төсөв тус тусдаа батлагддаг.	Их хааны төрийн сан, бага хаадын төрийн сан тус тусдаа татвар цуглуулж, төсвөө бүрдүүлж, захиран зарцуулдаг. Орон нутгийн сурвалжит язгууртнууд татвар хураахад гол үүрэг гүйцэтгэж, татварын нэг хэсгийг албан болон албан бус хэлбэрээр өөртөө үлдээн хамжлагат ардынхаа өмнө нутгийн удирдлагын үүрэг гүйцэтгэдэг.	Тухайлбал, Өгөдэй хаан өртөө зам тавих ажлыг дэмжиж Их хааны сангаас балыш (валют) хэмээх хаана ч хөрвөх чадвартай өндөр ханштай 300 алтан зоос гаргаж байв. МУ-ын түүх УБ., 1968. Ил хаант улс орд харш, одон орны төвийг өөрийн сангийн хөрөнгөөр барьж байсан. Жувеини
8	Холбооны ерөнхийлөгч. Бүх ард түмнээс сонгогдоно. Ерөнхийлөгч гүйцэтгэх засаглалыг тэргүүлнэ;	Их хааныг “Их Хурилдай”-гаар сонгоно. Их хаан нь хаадын хаан буюу холбооны гүйцэтгэх засаглалын бүх эрхийг барьдаг.	Өгөдэй, Гүег, Мөнх хааныг “Их хурилдай”-гаар сонгосон. МУ-ын түүх УБ., 1968.
9	Шүүх засаглал. Ард түмэн болон улс төрөөс үл хамааран бүх насаараа томилогдоно.	Төрийн “Их Заргач”-ийг Их хаан бүх насаар нь томилдог байв.	Чингис хаан Шихихутугийг төрийн их заргачаар бүх насаар нь томилсон. Монголын нууц товчоо. Ц.Дамдинсүрэнгийн орчуулга, УБ., 1947, 1976, 1990.

10	Нутгийн өөрөө удирдах ёсны бие даасан байдал	НӨУЁБ ард түмний гэдэг жинхэнэ утгаараа байхгүй. Гэхдээ харьяат орон нутгийн феодал, сурвалжитнууд улс төр ба татвар төлөхөөс бусад тохиолдлуудад нийгэм, эдийн засгийн асуудлаа бие дааж шийдвэрлэдэг байсан.	Вассал улсууд болон Орос зэрэг зарим газар татвар төлөх ажиллагааг эрх баригчдын хяналтын дор нутгийн уламжлалт язгууртнууд гүйцэтгэж байсан бөгөөд тэд өөрсдийн ард түмний нийгэм эдийн засгийн асуудлыг бие дааж асуудлаа шийдвэрлэдэг. МУ-ын түүх УБ., 1968.
11	Төрийн албан ёсны нэг хэлтэй байх	Монгол хэл их гүрний төрийн хэлний үүргийг гүйцэтгэж байсан хэдий ч бага хаант улсуудад тухайн орны томоохон үндэстний хэл зайлшгүй байдлаар тэр газар нутагтаа төрийн хэл болж байсан.	Хятад, Орос Иран зэрэг хүн ам олонтой улс орнууд дахь бага хаант улсуудад монгол хэлнээс гадна тэдний өөрсдийнх нь хэлийг төрийн хэлээр ашиглахаас өөр арга байгаагүй. Энэ нь түүхэн баримтуудад хадгалагдан үлдсэн. МУ-ын түүх УБ., 1968.
12	Олон шашин зэрэгцэн орших боломжтой байх	Аль нэгэн шашин, бөө мөргөлийг ч онцлон үзээгүй. Олон үндэстний оюун санааны асуудлыг зөрчилд оруулахгүйн тулд зайлшгүй хуульчлан хэрэгжүүлсэн.	Аливаа шашны суртахууныг хүндэтгэмой. Гэвч ямар нэг шашин онц эрхийг эдэлж үл болно. "Их Засаг" хууль, 43-р зүйл Хархүрэмд янз бүрийн шашны 12 сүм хийд байсан. МУ-ын түүх УБ., 1968.
13	Нэгдмэл холбооны зэвсэгт хүчинтэй байх	Томоохон дайн байлдааныг "Их хурилдай"-гаар хэлэлцүүлэн цэргийн нэгдмэл хүчээр шийдвэрлэж байсан. Гэхдээ бага хаант улсууд бие даасан арми, цэргийн хүчтэй болцгоосон байна.	1235 оны "Их хурилдай"-гаар Бат хааны хүсэлтийг шийдвэрлэж байсан бол, Мөнх хаан "Их хурилдай"-гаар Хулугу-д "Уулын өвгөд"-ийн асуудлыг шийдвэрлүүлэхээр цэрэг өгч байв. Бага хэмжээний дайныг тэд өөрсдийн хүчээр шийдвэрлэж байв. МУ-ын түүх УБ., 1968.

Их Монгол гүрний төрийн байгуулалттыг орчин үеийн холбооны төрийн байгуулалттай харьцуулж үзье. Үүнд:

1. **Холбооны нэгдсэн ерөнхий засаглал**-ын үүргийг Их Хааны засаглал гүйцэтгэж байв. Төрийн байгууламж нь үндэстний ба газар нутгийн холбооны улсын холимог шинжтэй. Том бага хаант улс болох "Алтан орд" славян, түрэг зэрэг олон үндэстэнээс гадна Их Армени, Новгород зэрэг вассалуудаас бүрдэж байсан. Гэхдээ тухайн үндэстэнүүдийн амьдарч байсан газар нутгийг "хүчээр" таслан хуваагаагүй. Бага хаант улсуудад засаглалын "ордны" хэв маяг зонхилж байхад Их хааны засаглал "Их Хурилдай", яамдууд бүхий институтжсэн хэлбэртэй байсаныг "Хар Татарын хэргийн товч", "Дай Юань улсын түүх" зэрэг олон эх сурвалжуудад тэмдэглэгдэн үлджээ.
2. **Засаглал хуваах тогтолцоо үйлчилдэг.** Их Хурилдай, Төрийн "Их Заргач" бүхий шүүх, Их хааны засгийн газар буюу яамдууд оршиж байсан. Энэ нь төрийн аппарат оршиж, засаглал тодорхой хэмжээнд хуваагдаж байсан гэж үзэх үндэстэй.
3. **Засаглалын хоёр тогтолцоо үйлчлэх.** Их хааны, бага хаант улсуудын болон вассаль буюу татвар төлөгч дагаар орсон улсуудын засаглал оршиж байв. Төрийн нэгдмэл үндсэн үүргийг "Их Хаан"-ы засаглал засаглал шийдвэрлэдэг бол бага хаант улсууд өөрсдийн улс төр, нийгэм, эдийн засгийн дотоод асуудлаа бие даан шийдвэрлэдэг онцлогтойг П.Карпинигийн "Монголчуудын түүх", Г.Рубрукын "Дорно этгээдэд зорчсон минь" зэрэг олон эх сурвалжуудад тэмдэглэгдсэн байна.
4. **Хуулийн хоёр систем үйлчлэнэ.** "Их засаг" хууль холбооны ерөнхий хуулийн үүргийг гүйцэтгэж байсан. Тухайлбал, "Их засаг" хууль дахь "Алив шашин суртлыг онцгойлон үзэхгүй" хэмээх заалт бага хаант улсуудад ч үйлчилж байв. Бага хаант улсууд "Их засаг" хуулийн хүрээнд Перс, Орос, Хятадад тэдгээр ард түмний өөрсдийнх нь хуульд түшиглэн засаглалаа хэрэгжүүлж байв. Энэ талаар Рашид-Ад-Дины "Судрын чуулган", "Юань Ши" зэрэг олон эх сурвалжуудад дурьдагдсан байдаг.
5. **Татварын гурван систем үйлчлэнэ.** Холбооны татварын тогтолцоог "Их Хаан"-ы санд нийлүүлэх бага хаант улсуудын татвар тухайлбал, Алтан Ордны улс Их хааны санд "ширток" хэмээх мөнгөн гулуузаар татвар төлж байсан болон Алтан Ордны улс өөрийн дотоод сангийн татвараа хураахын тулд хүн амын тооллого явуулж байсан баримтууд байдаг бөгөөд орон нутгийн сурвалжит язгууртнууд татвар хураах үүрэг гүйцэтгэхээс гадна татварын тодорхой хувийг өөртөө үлдээн орон нутгийн бие даасан хөгжлийг хангаж байв. Энэ эрхийн зөвшөөрлийг олж авсанаар Москва хүчирхэгжсэнийг

Оросын түүхэн баримтуудад дурьдсан байдаг.

6. **Хууль тогтоох 2 танхимтай парламент.** “Их Хурилдай” байнгын ажиллагаатай байгаагүй ч бага хаант улсуудыг тэдгээрийн хаад болон түүний удмынхан, орон нутгийг тухайлбал, вассаль улсуудыг тэдний ван, ноёд, төлөөний хүмүүс төлөөлөн их хурилдайд суудаг байв. Г.Рубрукын тэмдэглэлд “Их Хурилдай”-н сургаар Их Армений, Гүржийн, Новгородын төлөөлөгчид ирсэн байсан тухай дурьдагдсан байдаг.
7. **Холбооны болон муж улсууд, орон нутгийн төсөв тусдаа байна.** Их хааны, бага хаадын болон вассаль улсуудын дотоод төсөв тэдний удирдагчдын мэдэлд шийдвэрлэгдэж байсан бөгөөд энэ нь орчин үеийн институтжсэн хэлбэрт ороогүй ч эрх мэдэл нь хадгалагдан шийдвэрлэгдэж байсан нь нотлогоо шаардлагагүй логик ойлголт юм.
8. **Холбооны ерөнхийлөгч.** “Их Хаан” Их Хурилдайгаар сонгогдоно. Их хаан их гүрний ерөнхий гүйцэтгэх засаглалыг тэргүүлж, олон үндэстнээс бүрэлдсэн холбооны улс шинжтэй улсын төрийн нэгдмэл байдлыг хадгалан, задралаас сэргийлэх үүрэгтэй байв.
9. **Шүүх засаглал.** Чингис хаан Шихихутугийг төрийн “Их Заргач”-аар бүх насаар нь томилсон баримт нь шүүх засаглалын хараат бус байх үндэслэлийг тодорхой хэмжээнд хангаж байв.
10. **Нутгийн өөрөө удирдах ёсны бие даасан байдал.** Тухайн цаг нь дундад зууны үед хамаарах бөгөөд энэ үед нутгийн удирдлагын жам ёсны хэлбэр болох нийгмийн онол үйлчилж байсан. Энэ нь нутгийн удирдлагын үүргийг орон нутгийн сурвалжит язгууртнууд болон нутгийн феодалууд гүйцэтгэж ирсэн нийгмийн хөгжлийн жам ёсны хэлбэр гэж тодорхойлогддог. Үүнийг нотлох баримт нь эзэн ноёндоо хамжлага албат үнэнч зүтгэх нь төрдөө үнэнч зүтгэж буйтай адилтгадаг философи давамгайлж байсан. (Монголын нууц товчоо)
11. **Төрийн хэргийг албан ёсны нэг хэлээр явуулдаг.** Монгол хэл их гүрний төрийн хэлний үүргийг гүйцэтгэж байсан²⁹ хэдий ч бага хаант улсуудад тухайн орны томоохон үндэстэний хэл зайлшгүй байдлаар тэр газар нутагтаа төрийн хэл болж байсан. Хятад, Орос Иран зэрэг хүн ам олонтой газар бага хаант улсууд монгол хэлнээс гадна тэдний өөрсдийнх нь хэлийг төрийн хэлээр ашиглахаас өөр арга байгаагүй. Энэ нь тухайн улсуудын түүхэн баримтуудад хадгалагдан үлдсэн.
12. **Олон шашин зэрэгцэн орших боломжтой байх.** Аливаа шашны суртахууныг хүндэтгэмой. Гэвч ямар нэг шашин онц эрхийг эдэлж үл болно. “Их Засаг” хууль, 43-р зүйл. Хархүрэмд янз бүрийн шашны 12 сүм хийд байсан. Төр улсын нэгдмэл байдлыг хангах, шашин хоорондын зөрчлийг гүнзгийрүүлэхгүй байлгах зорилгоор шашин шүтэх эрх чөлөөг олгоод зогсохгүй, аль нэгийг нь онцлохгүй байх нь орчин үеийн холбооны улсын үндсэн шинжийн нэг юм.
13. **Нэгдмэл холбооны зэвсэгт хүчинтэй байх.** Томоохон дайн байлдааныг “Их хурилдай”-гаар хэлэлцүүлэн цэргийн нэгдмэл хүчээр шийдвэрлэж байсан. Өгөдэй хааныг нас барснаас хойших засаглалын хямрал нь бага хаант улсуудыг бие даасан арми, цэргийн хүчтэй болцгооход хүчтэй түлхэц үзүүлжээ. Үүнээс өмнө бага хаант улсуудад бие даасан цэргийн хүч байгаагүйг “Алтан Ордны” түүхэнд өгүүлсэн байдаг. Тухайлбал, “бослого, хөдөлгөөн, эсэргүүцэл болоход “Их Шивэр” ойн чинадах нутгийн гүнээс татарын морьт цэрэг “салхи, шуурга” мэт хурдлан ирдэг” хэмээжээ. Тухайлбал, Дундад Ази дахь Махмуд Тарабийн бослогыг дарахад Монгол нутгаас цэргийн хүч очиж байжээ.

Үүнээс үзвэл Их Монголын төрийн байгуулал, бүтэц зохион байгуулалт нь анхны холбооны улсын шинж чанартай байжээ гэж үзэж болно.

Холбооны институт нь төрийн тогтвортой байдлыг хангаж байсан нь

1241 онд Өгөдэй хаан нас барснаар хаан ширээ залгамжлах ахмад хөвүүд Европын аян дайныг зогсоож, ойролцоогоор 1242 оны үед буцаж ирцгээсэн. Их Хурилдай хуралдаж, шинэ “Их Хаан”-ыг сонгоход 1246 он хүртэлх хугацаанд Өгөдэй хааны хатан Турхан төр хамаарч байлаа гэж олон судлаачид үзэж, бичиж ирсэн билээ. Турхан хатны түр хугацаанд төр барьсаныг “ордны ёс”-оор тайлбарлах нь ямар ч боломжгүйг анхаарах хэрэгтэй юм. Учир нь уламжлалт “патриархал хаант ёс”³⁰, абсолют монархи (хэмжээгүй эрхт хаант засаглал)

²⁹ Д.Наран, Монголын төр ёсны боловсролын түүх, УБ., 2001, х. 99. Их хаан Өгөдэйн зарлигаар Их Монгол улсын төрийн албанд бичгийн мэргэдийг шалгаруулж авах зарын шалгуурт монгол хэл, бичгийг онцолсон байв.

³⁰ Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013. Тод Магнат ХХК. “Патриархал” гэдэг нь эцгийн эрхт овог гэсэн утгыг илэрхийлсэн Грек үг бөгөөд бурхан, тэнгэрээс заяасан угсаа залгамжилсан эрх мэдлийг хуульчилсанаар тодорхой хэмжээнд бие даасан язгууртнууд бүхий төр нийгмийн тухай ойлголт юм. Энэ нь тодорхой хэмжээний эрх мэдэл бүхий угсаа залгамжилсан язгууртнуудын легитимд тулгуурласан хаант засаглал юм. Патриархализмын үед эзэн хааны эрх мэдэл тодорхой хэмжээнд хязгаарлагдмал байдаг бөгөөд хаан улс орны хэмжээний томоохон шийдвэрийг бие даасан, угсаа залгамжлагч сурвалжит язгууртнуудын дэмжлэггүйгээр гаргах чадваргүй байдаг.

хоёрын аль алинд нь хааны хатан удаан хугацаагаар төр хамаардаг түүх аль ч улс орны түүхэнд байхгүй.

Уламжлалт патриархализмын нэг онцлог бол ордны ёсны анхдагч хэлбэр бөгөөд төрийн шийдвэрийг хаан ганцаар гаргах бус, харин түүний шийдвэр уламжлалт язгууртнууд болон шашны нөлөөлөлд хүчтэй автсанд байдаг аж. Учир нь угсаатны сурвалжит язгууртнуудыг хаан томилдоггүй бөгөөд тэд үндэс угсаанаас үе дамжин залгамжлагдан удирдаж ирсэнээрээ хаанаас хараат бус юм. Угсаатны сурвалжит язгууртнууд өөрийн гэсэн бие даасан албат ард, цэрэг арми, эдийн засаг, газар нутагтай байдаг тул, хааны шийдвэр таалагдаагүй нөхцөлд түүнд захирагдахгүй байх чадвартай төдийгүй, зарим тохиолдолд хааны шийдвэр тэдний санаанд нийцэхгүй буюу эрх ашгийг нь хохироовол эсэргүүцэн тэмцэж улс орныг хямраадаг. Үүнээс гадна хааны санд нийлүүлэх татварыг өөрийн санаанд нийцүүлэн өгөхийг хүсдэг бөгөөд эзэн хаан байгалийн гамшиг, дайн, томоохон баяр ёслол зэрэг онцгой тохиолдолд татварыг хүссэнээрээ дайчлан авч чаддаг байна. Дайн болон гамшигийн дайчилгаа нь төр нийгмийн шинжтэй хааны легитимийг дээшлүүлэх гол хэрэгсэл болдог бол, харин томоохон найр цэнгээн, баяр ёслол нь уламжлалт язгууртнуудын хаанд шадарлан эрх мэдэл, байр суурна бэхжүүлэх хоорондын өрсөлдөөний зорилгод ашиглагддаг. Патриархализмын үед хаан нас барахад хаан ширээний төлөө ураг төрлийн тэмцэл зайлшгүй үүсдэг бөгөөд үүнд бие даасан сурвалжит язгууртнууд хаан ширээний төлөө тэмцэгчдийн талд хуваагдан тэмцэлдэж улс орны тогтвортой байдлыг алдагдуулдаг байна. Энэ тэмцэлд ялсан тал нь ялагдагчидаа гэсгээн цээрлүүлсэнээр нийгэмд элитийн циркуляци явагддаг ажээ.³¹ Хэрэв удаан хугацаанд хаангүй, хаан ширээ залгамжлагчгүй тохиолдол байх тохиолдол гарвал нэгдмэл төр улс оршиж чаддаггүй байж. Учир нь тэд нэгдмэл нэг үндэстэний төр улс болж чадаагүй байсантай холбоотойгоор бие даасан язгууртнууд өөр өөрийн жижиг аймаг, ханлиг, хот, улсыг бий болгон бутардаг байсан бөгөөд хэрэв цэрэг, улс төр, эдийн засгийн хүчний тэнцвэр тогтсон нөхцөлд энэ нь тодорхой хугацаанд удаанаар тогтвортой хадгалагддаг. (Тухайлбал, 1136-1180-аад оны Монголын ханлигууд, Гарибальдаас өмнөх үеийн Итали г.м.) Харин гадаад хүчний аюул буюу харь улсын довтолгоон, эсхүл дотоодын хүчний тэнцвэр алдагдах зэрэг нөхцөл тогтворгүй байдлыг үүсгэдэг. Тогтворгүй байдлын гадаад нөхцөл нь нэг бол харь улсад эзлэгдэх, эсхүл нийтийн дайсны эсрэг эвлэлдэн тэмцэх байдалд хүргэдэг. Харийн түрэмгийллийг няцаасны дараа ихэвчлэн хүчний тэнцвэрт байдлаа хадгалж үлддэг. Харин дотоодод хүчний тэнцвэр алдагдсан тохиолдолд давуу хүчийг олж авсан хүчний тэмцлээр улс орон нэгддэг аж. (Жишээ нь Тэмүжин, Тоорил, Жамух нарын цэрэг улс төрийн хүчний эвсэл, Пруссийн манлайлалын доорхи Германы нэгдэл г.м.)

Энэ нөхцөлд хааны засаглал орон нутгийн бие даасан удирдлагуудыг нэгтгэн зангидахын тулд хааны хувийн харизм, язгууртнуудын олонхийн дэмжлэг, шагнал урамшуулалд тулгуурласан эеэр татах бодлого, эсхүл гадны улс орнуудын аюул заналын дор нэгдэх, гадагш түрэмгийлэх аян дайн зэрэгт л тулгуурлахаас өөр боломж бага байдаг ажээ. Хааны зүгээс томоохон дайн байлдааны ялалтаас олсон олз омог, түүний сүр хүч, легитимийг дээшлүүлэх гол нөхцөл болдог бөгөөд энэ үед л хаан өөрийн санаанд нийцээгүй сурвалжит язгууртнуудын угсаа залгамжлалыг өөрчлөх хүчийг олж авдаг байна. Патриархализмын үеийн хааны засаглалын гол тулгуур нь түүний тойрон хүрээлэлд суурилдаг бөгөөд үүнд шадар (итгэлт) түшмэл, цэргийн жанжин, “нөхөр” цэргүүдийн (фаворитизм) тойрон хүрээлэл нь ураг төрлийн холбооноос илүү чухал байдаг аж. Үүний учир нь хаанд дургүйцсэн сурвалжит язгууртнууд хааны цусан төрлийн холбоотон хэн нэгний хүсэл шунал болон бусад хүчин зүйлийг ашиглан дэмжиж хааны засаглалыг солихыг эрмэлздэгт оршдог. Ийм замаар түүхэн дэх ах дүү нарын хаан ширээ, эрх мэдлийн төлөөх тэмцэл явагддаг. Тухайн цаг үед патриархализмын элементүүд амь бөхтэй оршиж байсан нь эргэлзээгүй. Энэ тохиолд хэн нэгэн хаан ширээг түр орлогчийг хэн ч хүлцдэггүйг эртний болон дундад зууны үеийн олон улс орнуудын түүх гэрчилдэг. Тиймээс ч Турхан хатны төр барьсаныг өөр институтжсэн тогтолцоо хүлээн зөвшөөрүүлж байсан гэж үзэх үндэстэй.

Абсолют монархи буюу хэмжээгүй эрхт хаант засаглалын онцлог бол төр улсын нэгдмэл байдлын шат ахисан хэлбэр бөгөөд эзэн хаан сурвалжит язгууртнуудын эрх мэдлийг хязгаарлаж, өөрийн эрх мэдлийг хэмжээгүй нэмэгдүүлсэн тогтолцоо юм. Энэ нөхцөлд орон нутгийн сурвалжит язгууртнуудаас илүү эзэн хаандаа үнэнч үйлчлэх түшмэдийн тогтолцоо тэргүүн зэрэгт тавигддаг. Эзэн хаанд зүтгэдэг, түүний хувийн удирдлагын аппарат мэт хүчирхэг түшмэдийн тогтолцоо бүхий абсолют монархийн хөгжил нь ордны ёсыг халж, төрийн удирдлагын аппарат хөгжихөд гол үүрэг гүйцэтгэсэн юм. Патриархализмын үед эзэндээ үнэнч зүтгэх зарчим түшмэдийн гол шалгуур болж байсан бөгөөд тухайлбал, эзэн хаан болон төрөөс илүү өөрийн эзэнд үнэнч үйлчлэх явдал чухал байсан. Ийм ч учраас эзэн нь түшмэдээ угсаа залгамжлуулах бус үнэнч итгэлтэй байдлыг гол шалгуур болгож байв. Харин абсолют монархийн түшмэл нь хаан төдийгүй төрийг төлөөлдөг байснаараа нэр хүнд, ёс суртахуун, эрх мэдэл зэрэг олон талаар уламжлалт түшмэдээс илт давуу, ахисан түвшний хөгжил бөгөөд үүнийг М.Вебер “патримониаль бюрократ” гэж нэрлэсэн байдаг. Тиймээс ч тэдгээр патримониаль бюрократ түшмэдийн үйлдэл, үйл ажиллагаа төрийн тогтвортой байдлыг хангах нэг үндэс болж байв.

³¹ Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013. Тод Магнат ХХК.

Их Монголын төрд ордны ёс, хэмжээгүй эрхт хаант засаглалын шинжүүд ямар нэг хэмжээгээр байсан гэж үзэж болох хэдий ч түүнээс илүү ахисан түвшний засаглал оршиж байсан нь гарцаагүй гэдгийг 1242-1246 оны болон 1248-1251 оны улс төрийн хямралууд, түүнийг даван туулсан улс төрийн үйл явц, үзэгдлүүд харуулж байдаг. Хэрэв уламжлалт хаант засаглалын тогтолцоо байсан бол жил ч хүрэхгүй хугацаанд их төр задрах байсан. Хэмжээгүй эрхт хаант засаглал байсан бол шууд хүч хэрэглэж сөрөг хүчнээ нухчин дарах оролдлого эхлэх байсан. Тэгэхээр аль нь ч биш болох нь тодорхой юм.

Их хаан буюу төрийн аппаратад хамаарах түшмэд нь төрийн зүтгэлтнүүд буюу төрийн түшмэлд тооцогддог байв. Тэдгээр түшмэд их хааны нэрийн өмнөөс хувийн дур зоргоор төрийн хэргийг гүйцэлдүүлэх явдал тодорхой хязгаартай байв. Учир нь тэд бага хаант улсуудын эрх мэдэл, эзэмшил нутаг, хүн амд хандах эрхгүй бөгөөд их хааны зүгээс гаргасан их гүрний хэмжээний ерөнхий хууль, зарлиг, тогтоолын хүрээнд бага хаант улсуудыг барьж байх тодорхой удирдлагын хэрэгсэл болж байсан ажгуу. Түүхэн сурвалжуудад дурьдсанаар “Их Хаан” сонгох “Их Хурилдай”-г хуралдуулахгүй удаасан явдал Турхан хатнаас илүүтэй төрийн түшмэдүүдтэй холбоотой байсан бололтой. Учир нь түшмэдүүд улс төрийн хүчнүүд (Гүег, Бүри болон Бат, Мөнх нарын бүлэглэлүүд)-ийг урьдчилан эв зүйгээ олохыг хүсэмжилж хурилдайг хойшлуулж байсан нь илүү магадлалтай юм. Хожим нь Гүег их хаан болоод олон түшмэдийг түүний дунд Чингис хаантай хамт их төрийг байгуулсан алдарт Юлуй Чуцай буюу Чу мэргэнийг цээрлүүлсэн нь үүнтэй холбоотой байж болох юм. Тухайн хүний үг, үйлдэл түүний хандах зүгийг чиглүүлдэг агаад Чу мэргэний өмнө хийсэн үг, үйлдлүүд нь энэхүү улс төрийн хямралын цаг үеийг зэвсгийн хүчээр шийдвэрлэхгүйгээр хууль ёс, яриа хэлэлцээр, эв эеэр шийдвэрлэх гэж оролдож байсан нь зайлшгүй гэдэг логик харагдаж байгаа юм. Мөн түүнчлэн Их хаан Гүег, Бат хаан хоёрын эвдрэлцээн дайнд хүргэсэн хэдий ч Их хаан Гүег цэрэглэж чадаагүй нь “Их Хурилдай”-гаар нэгдсэн цэргийн хүч хөдөлгөдөг хууль ёс саад болсон байхыг үгүйсгэх аргагүй юм. Тухайн цаг үед Их Монгол гүрний төрд засаглал хуваах зарчим ямар нэгэн хэмжээгээр хэрэгжиж байсныг тогтоол шийдвэр гаргадаг “Их хурилдай”, түүнийг хэрэгжүүлдэг их хааны засаглал, “Дотоод Бичгийн Яам” хэмээх төрийн аппарат, бүх насаараа томилогддог “Их Заргач” хэмээх шүүх засаглал гэрчилэхээс гадна төрийн байгуулалт нь анхны холбооны төрийн байгууламжтай байжээ гэсэн дүгнэлтийг өгөхөд хүргэж байна. Эдгээр болон бусад баримт, эх сурвалжууд Их Монгол гүрний төрийг бага боловч институтжсэн бүтэцтэй байсан гэдэг таамаглал дэвшүүлэх бүрэн үндэстэй төдийгүй, цаашид судлаачид анхаарлаа хандуулан судалбал, үүнээс ч илүү олон баримтууд олдох магадлал өндөр юм.

Философичид түүхэн үйл явцын тодорхой зүй тогтлыг мэдэрдэг билээ. Тухайлбал, “Хүн төрөлхтний түүх дорноос, Монголоос эхэлдэг. Учир нь тэнд төр байсан юм. Төрөө цогцлоож байж сая зон олон нь ард түмэн болдог” гэсэн Георг Вилгельм Фридрих Гегелийн алдарт үг, философич Д.Чулуунжавын “Их Монгол улс оршин тогтнож ирсэн 54 жилийнхээ 20 хувьд нь буюу нийтдээ арван жилийн туршид Их хаангүй байсан. Их хааныг товлон сонгож завдахгүйгээр өнгөрөөсөн эл 10 жилийн дотор улс орон эвдэрч, төр самуурч, дотооддоо хямарч болох байсан хэдий ч тийм талын сөрөг үзэгдэл бараг байхгүйгээр харьцангуй тайван өнгөрөөжээ. Арван жилийг хаангүйгээр байж чадсан нь тухайн цагийн Монголын төрийн байгуулал хэр их бат бэх, хэр сайн зохион байгуулалттай, хэр их амьдрах чадвартай, хэр их хүчтэй уламжлал, энерги бүхий байсныг харуулах нэгэн шалгуур мөн болно”³² гэсэн нь үүнийг нотлох буйзаа.

ABSTRACT:

This paper shows that scientists & scholars works and studies which based on historical source, history of the State Development of Great Mongolian Empire in XIII century. As a result of this study, to make evidences and examples around the federal structure of the model, to approve based on assumptions proved facts that created the State structures in the world first time.

The Framework of study political system Mongolian States (1206-1227); Great Mongolian Empire (1229-1260); The decomposition of Great Mongolian Empire & Yuan Dynasty (1261-1368) which could be determined to divide into three phases.

Main goal of this paper is to report the Mongolian State's structures newly to give its valuables make conclusion. Three main studies posted in this study.

First, the studied State's structure & system of Great Mongolian Empire. Secondly, Modern new state structures of other countries have been analyzed based on empirical facts of Great Mongolian dynasties & State environment which were based on 7 basis the federal government arrangements.

Third, to determine the how to provide state sustainable situations of State when the right political struggle for power between 1241-1246, the goal was to clarify was how to maintain political stability.

As a result of the comparison studies:

³² Д.Чулуунжав, Монголын байлдан дагууллын шалтгаан, нөхцөл, үр дагаварын асуудалд, /Философи эрхийн судлал, боть 20, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи, Философи Социологи Эрхийн Хүрээлэн/ УБ., 2006, х 216.

First, Great Mongolian dynasties were government ministries with patrimonial bureaucratic apparatus.

Second, Great Mongolian Empire existed between 1229-1260 that was a federal model.

Third, it could made conclusions which shows the state development communication model and state administrative apparatus political stability that could satisfy without “Great King” for 10 years.

НОМ ЗҮЙ:

1. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх, УБ., 1981.
2. Монголын нууц товчоо, Ц.Дамдинсүрэнгийн орчуулга, УБ., 1947, 1976, 1990.
3. Ц.Дамдинсүрэн, Мянган жилийн харьцуулсан хүснэгт, УБ., 1995.
4. Д.Мөнх-Очир. Суут одон орон зурхай судлаач Елюй Цуцай. УБ., 2005.
5. Плано Карпини. Монголчуудын түүх. УБ., 1988.
6. Г.Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988.
7. Дай Юань улсын түүх. Хөх хот. 1987.
8. Д.Наран, Монголын төр ёсны боловсролын түүх, УБ., 2001.
9. Ц.Батболд. Бюрократ онолын үндэс. УБ., 2013. Тод Магнат ХХК.
10. Ч.Жүглэр, Монголд феодализм тогтох үеийн нийгэм улс төр гүн ухааны сэтгэлгээ, УБ., 2002.
11. М.Дюверже. Улс төрийн байгууламж Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007. Монсудар ХГ.
12. Ч.Арьяасүрэн. Х.Нямбуу. Монгол ёс заншлын Их тайлбар толь. УБ., 1992.
13. Д.Чулуунжав, Монголын байлдан дагууллын шалтгаан, нөхцөл, үр дагаварын асуудалд, /Философи эрхийн судлал, боть 20/ УБ., 2006.
14. Ц.Батболд, Монголд тулгар төр тогтох үе дэх улс төрийн засаглалын патримониальмагийн хэв шинжийн онцлог, МУИС, НШУС, Эрдэм шинжилгээний бичиг, № 245 Түүх IV (24), 2005.
15. М.Вебер. Избранные произведения. М., 1990.
16. А.В.Оболонский. Государственная служба, М., 2000. Дело.
17. М.В.Масловский. Теория бюрократии Макса Вебера и современная политическая социология, /Полис/ М., 1997.
18. Каменка Е. Bureaucrasy. Oxford, 1989. P.63.
19. Э.Н.Ожиганов. Политическая теория Макса Вебера, Критический анализ. Рига., 1986
20. М.В.Масловский. Теория бюрократии Макса Вебера и современная политическая социология /Полис/. М., 1997.
21. Г.В.Атаманчук. “Теория государственного управления” М., 1994.
22. Albrow M. Bureaucrasy. L., 1970.
23. Webster’s Encyclopedic Unabridged Dictionary. Distributed by Random House. New Jerseys. 1994.
24. M.Weber, Wirtschaft und Gesellschaft. Tubingen, 1976.